



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 29 өдөр

Дугаар #197

Мандалговь

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн “Дүрэм, жагсаалт батлах тухай” А/536, “Заавар батлах тухай” А/537, “Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварыг тандах заавар батлах тухай” А/539 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн “Халдварын сэргийлэлт, хяналтын баг”-ийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 31, 11 дүгээр сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Сургалтын удирдамж, хөтөлбөрийг нэгдүгээр, зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Сургалтын үйл ажиллагаанд зарцуулагдах 851,500 (найман зуун тавин нэгэн мянга таван зуун) төгрөгийг хөтөлбөр арга хэмжээний зардлаас гаргахыг ерөнхий нягтлан бодогч (Т.Одонцэцэг)-д зөвшөөрсүгэй.

4.Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (Б.Саруулцэцэг)-т даалгасугай.

ДАРГА  Б.АЛТАНТӨГС



Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн
А/97 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

**ЭМНЭЛЭГ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮДИЙН “ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ,
ХЯНАЛТЫН БАГИЙН ГИШҮҮДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ”-ЫН
УДИРДАМЖ, ХӨТӨЛБӨР**

ЗОРИЛГО:

Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн “Халдварын сэргийлэлт, хяналтын баг”-ийн гишүүдийг чадавхжуулж эмнэлгийн халдварын сэргийлэлт хяналтын үйл ажиллагааг сайжруулах, эмнэлэгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх.

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

- Эрүүл мэндийн газар

ХУГАЦАА:

- **2024 оны 10 дугаар сарын 31-ний өдөр:** Дэлгэрцогт, Дэрэн, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Өндөршил, Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Өлзийт сумдын эрүүл мэндийн төвүүд,
- **2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр:** Луус, Хулд, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Адаацаг сумдын болон Боржигонмандал, Өлзийтмандал өрхийн эрүүл мэндийн төвүүд “Элбэрэлбуян” хувийн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны Нэгдсэн эмнэлэг, Нэгдсэн эмнэлэг.

ХАМРАХ ХҮРЭЭ:

- Эмнэлэг, эрүүл мэндийн төв тус бүрээс 3 хүн (“Халдварын сэргийлэлт хяналтын баг”-ийн ахлагч, ариутгагч, хог хаягдал хариуцсан үйлчлэгч),

САНХҮҮЖИЛТ:


- Эрүүл мэндийн газрын Хөтөлбөр арга хэмжээний зардал

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР:

Хугацаа	Сэдэв	Хариуцагч
08:30-09:00	Бүртгэл	Зохион байгуулагчид
09:00-09:10	Нээлт	Эрүүл мэндийн газрын дарга Б.Алтантөгс
09:10-09:30	Халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр хэрэгжиж буй тушаал, шийдвэр, Магадлан итгэмжлэлийн шалтгалтаар илэрч буй алдаа, зөрчлүүд анхаарах асуудал	НЭМХ-ийн дарга Б.Саруулцэцэг
09:30-10:00	Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд ажиллах “Халдварын сэргийлэлт хяналтын баг”-ийн томилгоо, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, анхаарах асуудал	НЭМХ-ийн дарга Б.Саруулцэцэг
10:00-10:30	Цайны завсарлага	Зохион байгуулагчид

10:30-11:00	Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын тандалт хийх заавар (Илрүүлэлт, бүртгэл мэдээлэлт)	НЭМХ-ийн мэргэжилтэн, тархвар судлагч Д.Цэрэнчунт
11:00-11:50	Эрүүл мэндийн ажилтны гар угаалт, халдваргүйжүүлэлт. Дотоод хяналт хийх үнэлгээний хуудас, үнэлгээ хийх арга зүй. Дадлага ажил	НЭМХ-ийн мэргэжилтэн, талбарын тархвар судлагч Н.Цогзолмаа НЭМХ-ийн мэргэжилтэн, тархвар судлагч Д.Цэрэнчунт
11:50-12:20	Эмнэлгийн тоног, төхөөрөмжийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх, ариутгах заавар. Дотоод хяналт хийх үнэлгээний хуудас, үнэлгээ хийх арга зүй.	НЭМХ-ийн мэргэжилтэн, талбарын тархвар судлагч Н.Цогзолмаа
12:20-12:40	Эмнэлгийн ажилтныг халдвараас сэргийлэх үйл ажиллагаа.	НЭМХ-ийн мэргэжилтэн, тархвар судлагч Д.Цэрэнчунт
12:40-13:00	Хамгаалах хувцас хэрэгсэл зөв хэрэглэх заавар	НЭМХ-ийн мэргэжилтэн, тархвар судлагч Д.Цэрэнчунт
13:00-14:00	Өдрийн завсарлага	Зохион байгуулагчид
14:00-14:30	Эрүүл мэндийн байгууллагын цэвэрлэгээ хийх заавар Хяналтын хуудас, дотоод хяналт хийх үнэлгээний хуудас, үнэлгээ хийх арга зүй	НЭМХ-ийн мэргэжилтэн, талбарын тархвар судлагч Н.Цогзолмаа
14:30-15:00	Эмнэлгийн зөөлөн эдлэл, цагаан хэрэглэл угаах, хэрэглэх заавар Угаалгын газрын үйл ажиллагаанд дотоод хяналт хийх үнэлгээний хуудас, үнэлгээ хийх арга зүй	НЭМХ-ийн мэргэжилтэн, талбарын тархвар судлагч Н.Цогзолмаа
15:00-15:30	Уламжлалт эмчилгээ, сэргээн засах тусламж үйлчилгээний халдварын сэргийлэлт, хяналтын заавар	НЭМХ-ийн мэргэжилтэн, тархвар судлагч Д.Цэрэнчунт
15:30-15:45	Цайны завсарлага	Зохион байгуулагчид
15:45-16:15	Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах ялгах, цуглуулах заавар	НЭМХ-ийн Орчны эрүүл мэнд, хоол тэжээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Ширчмаа
16:15-16:45	Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг эмнэлэг дотор зөөвөрлөх, хадгалалт үйл ажиллагааны заавар	НЭМХ-ийн Орчны эрүүл мэнд, хоол тэжээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Ширчмаа
16:45-17:15	Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг тээвэрлэх заавар	НЭМХ-ийн Орчны эрүүл мэнд, хоол тэжээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Ширчмаа
17:15-17:45	Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг устгах заавар Хог хаягдлыг автоклавт халдваргүйжүүлэх ажиллагааны зааварчилгаа	НЭМХ-ийн Орчны эрүүл мэнд, хоол тэжээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Ширчмаа
17:45-18:00	Асуулт, хариулт	Нийт оролцогчид
18:00-18:10	Хаалт	Зохион байгуулагчид

Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн
А/97 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Тоо, ширхэг	Нэгж үнэ	Дүн
1	Кофе, аяга	70*2 удаа	700	98,000
2	Сендвич	70*2 удаа	4,500	630,000
3	Бичгийн цаас	1	18,500	18,500
4	Бал	70	1,500	105,000
Нийт				851,500